

**“ГТХЗНТ” УТУГ-ЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН НЭГЖҮҮДИЙН  
2024 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2024 оны 5 дугаар сарын 06

Дугаар08

“ГТХЗНТ” УТУГ

**Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго**

“ГТХЗНТ” УТУГ-ын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн батлуулсан нэгжүүдийн 4 дүгээр сарын төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал зөвлөмж боловсруулах, удирдлага, ажилтнуудыг мэдээллээр хангаж, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнг нэмэгдүүлэх, хэрэгжилт хариуцлагыг сайжруулах зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

**Хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал**

Нэгжүүдийн төлөвлөсөн ажлын гүйцэтгэлийг төлөвлөгөөнд урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин, хүлээгдэж буй үр дүнтэй харьцуулж хяналт-шинжилгээ, үнэлгээний журамд заасан аргачлалаар үнэлэв.

**Үнэлэлт**

Нэгжүүдийн сарын төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хэрэгжилтийн байдлыг хүснэгтээр үзүүлэв.

Нэгжийн нэр	Төлөвлөсөн ажил	Үүнээс							Биелэлт /хувиар/
		100%	90%	70%	50%	30%	0%	ХБ	
ЗСХ	12	6	1	2	1	1	1	-	76.0
ТНУАСХ	15	12	1	1	1	-	-	-	94.0
ГХБАБМХ	4	4	-	-	-	-	-	-	100
<b>Дүн</b>	<b>31</b>	<b>22</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>2</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>87.8</b>

**Дүгнэлт**

Нэгжүүд 4 сард төлөвлөсөн 31 ажлын 77.4 хувийг бүрэн хэрэгжүүлсэн, 22.6 хувийг хэрэгжүүлж дуусаагүй байна.

Зам, тээврийн хөгжлийн сайдын шуурхай хуралдаан тайлант сард 1 удаа хуралдаж харьяа байгууллагуудад нийтлэг өгсөн 3 үүрэг даалгавар биелсэн байна.

Тайлант сард хариутай 30 ирсэн албан бичиг бүртгэгдэж, 22 бичгийг хугацаанд нь шийдвэрлэсэн байна. Шийдвэрлэх хугацаа болоогүй 6, шийдвэрлэх шатанд 1, хариу өгөөгүй 1, төвийн хэмжээнд ирсэн баримт бичиг шийдвэрлэлт 91.7 хувьтай байна. Үүнд:

ЗТХЯ-ны СХГ-ын 2024.04.03-ны өдрийн “Журам, аргачлал хэрэгжүүлэх тухай” 11/1400 дугаартай албан бичиг шийдвэрлэх шатанд, ХШҮДАГ-ын 2024.04.02-ны өдрийн “Төлөвлөгөө хүргүүлэх тухай” 10/1372, ТНБД-ын 2024.04.03-ны өдрийн “Хөтөлбөр хэрэгжүүлэх ажиллах тухай” 03/1404, Койкагийн 2024.04.08-ны өдрийн “Сургалтад хамруулах тухай” 2024-78, ТЗУГ-ын 2024.04.12-ны өдрийн “Арга хэмжээ зохион байгуулах тухай” 05/1567, БТГ-ын 2024.04.19-

ний өдрийн “Төлөвлөгөө хүргүүлэх тухай” 04/1690, ЗТХ-ийн дэд сайдын 2024.04.22-ны өдрийн “Албан даалгавар хүргүүлэх тухай” 02/1716 дугаартай албан бичгийг шийдвэрлэж хариу өгөх хугацаа болоогүй байна.

Тайлант сард төвөөс явуулсан хариу ирүүлбэл зохих 29 албан бичиг бүртгэгдсэн ба 16 бичигт хариу ирж, шийдвэрлэгдэх шатанд 2, хугацаа болоогүй 8, хариу ирээгүй 3, явуулсан бичгийн шийдвэрлэлт 76.2 хувьтай байна. Үүнд:

Төвөөс Архивын ерөнхий газарт 2024.04.03-ны өдөр баримт бичиг хадгалах хугацааны жагсаалт хүргүүлэх тухай 251, “Шарын гол” ХК, “Төмөр замын зураг төслийн институт” ХХК-д 2024.04.25-ны өдөр хөдлөх бүрэлдэхүүний мэдээлэл ирүүлэх тухай 331, 332 дугаартай албан бичгийн хариу ирээгүй байна.

Төвөөс Хот байгуулалт, хөгжлийн газарт 2024.04.12-ны өдөр хүргүүлсэн барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл хүсэх тухай 271, ТХААГ-т 2024.04.15-ны өдөр хүргүүлсэн тендер зохион байгуулах тухай 278 дугаартай албан бичгүүд шийдвэрлэгдэх шатанд байна.

Төвөөс “ТТЗ” ХХК, “МТЗ” ТӨХК, “УБТЗ” ХНН, ЗТХЯ, “УБЦТС” ТӨХК, “МХС” ХХК, “УБДС” ТӨХК, УСУГ-т 2024.04.04, 2024.04.15, 2024.04.24-ний өдөр хүргүүлсэн 252, 253, 254, 274, 323, 324, 325, 326 дугаартай албан бичгүүд шийдвэрлэх хугацаа болоогүй байна.

#### **Санал зөвлөмж**

1. Төвийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3, 4, 9, 10, 11, 12, 13, 15, 19, 20, 22, 23, 27, 28, 29, 30-д тусгагдсан 16 арга хэмжээг хариуцсан нэгж, ажилтан II улирлын зорилтот түвшний дагуу хэрэгжүүлж ажиллах; (төлөвлөгөөний зорилтот түвшнийг уншаарай)

2. БНСУ-д сургалтад хамрагдах ажилтнууд сайдын тушаал, албан даалгавар, гүйцэтгэлийн төлөвлөгөө, нийтийн мэдээллийн ил тод байдал, туслах чанараар баталсан төлөвлөгөө, захирлын тушаал зэрэг 2024 оны хагас жилээр ЗТХЯ-нд тайлагнах мэдээ, тайлангийн биелэлт, хэрэгжилтийг

3. ХАБЭА-н сарын аян зохион байгуулсан тухай тайлан мэдээллийг зам, тээврийн салбарын ХАБЭА-н салбар хороонд 2024.05.06-ны дотор албан бичгээр болон цахимаар тайлагнах;

4. Зам, тээврийн салбарын хэмжээнд зохион байгуулж буй “Байгууллагын соёл, ёс зүй” арга хэмжээний удирдамжид заасан ажлуудыг хэрэгжүүлж тайланг яамны ТЗУГ-т 2024.05.31-ний дотор тайлагнах;

5. Зам, тээврийн салбарын ХАБЭА-н салбар хорооны 2024 оны төлөвлөгөөний биелэлтийн тайланг зам, тээврийн салбарын ХАБЭА-н салбар хороонд 2024.06.01-ний дотор тайлагнах;

6. ХНХЯ, Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2024.03.29-ний өдрийн “Зам, тээврийн салбарт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангаж ажиллах тухай” 07/00-00/001-04 дугаартай албан даалгаврыг хэрэгжүүлж тайланг зам, тээврийн салбарын ХАБЭА-н салбар хороонд 2024.06.01-ний дотор тайлагнах;

7. Ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.3.6-д заасны дагуу төвийн вэбсайтад байршуулж нээлттэй мэдээлэх;

8. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.4.10, Шилэн дансны тухай хуулийн 6.4, 6.4.3-т заасны дагуу тендерийн баримт бичиг, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй үндэслэл, шалтгааныг төвийн вэбсайтад байршуулж мэдээлэх;

9. ЗТХЯ-ны ТЗДТБЗГ-ын даргын баталсан Төмөр замын тээврийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийг дагаж мөрдөхтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хариуцан хэрэгжүүлэх;

**ТАНИЛЦСАН:**

“ГТХЗНТ” УТУГ-ЫН ЗАХИРАЛ

ГХБАБМХ-ИЙН ДАРГА

ТНУАСХ-ИЙН ДАУХГ

**ХЯНАСАН:**

ЗСХ-ИЙН ДАУХГ

**БОЛОВСРУУЛСАН:**

ХШҮМ

А.БУЯННЭМЭХ

Ц.ОЮУНБАТ

Ж.АЛИМАА

С.ЗОЛЗАЯА

Э.ОСОРЖАМАА

*Э. Осоржамбаа*  
2/107